

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пунцагдуламын Лувсанданзан	Дугаар	L028
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Их хүрээ	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хүрээний Эрхэмийн аймгийн дуган	Сүм хийдийн дугаар	UBNR 942
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	UB 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Хүрээний Эрхэмийн аймгийн дуган

Би Зүүн хүрээнд төрсөн. Энэ Дашчойлон хийдийн хойно Эрхэмийн аймаг гэж байсан юм. Одоогийн байгаа хойд дуганд би 5 настай лам болоод 11 настайдаа хар болсон. Би дацанд хурах нас хүрээгүй байсан. Би Зүүн хүрээнд байсан. Гандангийн хүүхдүүд яаж байсныг мэдэхгүй. Хотын Намын хороо гэж байсны тэнд хүрээний бүх лам хүүхдийг аваачаад данслаад хар болгосон юм. Тэгж хар болсон. 1990 онд эргээд лам болсон. Хүрээ 30 аймагтай байсан.

Шүтээний, Дондовлин, Жиддаран, Даштойсомлин, Дүйнхорын, Цэцэн тойны, Андуггийн, Дашдандарлин, Махасамаяагийн, Жасын, Номчийн, Сангайн, Зоогийн, Дугарын, Чойнхорлин, Мэргэн хамбын, Бизъяагийн,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хүүхэн ноёны, Дархан эмчийн, Эрхэм тойны, Эх дагинын, Вангайн, Эрдэнэ хувилгааны, Баргын, Намдоллин, Бандидын, Сүнгийн, Лам нарын, Мэргэн номун ханы, Өрлүүдийн гэсэн.

1936, 1937 оны үед аймгуудын бурхан тахилыг нь буулгаад хэмхчээд ном судрыг нь одоо энэ баруун талд Вангай аймаг гэж байсан, энэний хашаанд бурхан тахилыг нь хураагаад ном судрыг нь шатаасан юм. Энэний цаад талд хуучин цирк гэж байгаа шүү дээ. Энэ бол Эх дагинын аймаг байсан юм. Энэ Эрхэмийн аймаг, Сангай аймаг 2 чинь дундуураа явган жижигхэн сургааган хашаатай байсан юм. Манай аймгийн дуганын хаалга зүүн тийшээ харсан жижиг хаалга байсан. Тэрний араар явган сургааган хашаа байсан юм. Манай аав Эрхэмийн аймгийн лам байсан юм. Сүүлдээ Эрхэмийн аймгийн тогооч, нярав хийж байгаад хуучин Шашны яам гэж байсан тэнд Гомбодоо гэдэг хүнд энэ бүх зүйлийн түлхүүрийг нь өгсөн.

11 настай хар болоод тэгээд тэр голын Цэнгэлдэхэд бид зуны 3 сар бөөнөөрөө байж байгаад би намын дээд сургуулийн тэнд байсан бага сургууль гэж 2 давхар цагаан байшин байсан тэнд ороод бусад нь офицерийн сургуульд орсон. Тэгээд 1 жил тэндээ сураад Үлгэр жишээч сургуульд 3 жил сураад 4-р анги төгсөөд ХАА-н техникумд орсон.

ХАА-н техникумаас суралгүй гараад хар ажил голдуу хийж байсан. АДБЧ-д өвөл нь сантехникийн слесарь болоод зун нь үрлагийн бригад дагаж баруун 5 аймгаар явж билет зарна. Мөн манаач, дэлгүүрийн худалдагч зэрэг ажил хийж байсан. Тэгээд 1991 онд шашин маань дахин сэргэж би хүрж эхэлсэн юм.

Эрхэмийн аймаг 300 ламтай байсан. Намайг бага байхад өглөө эрт 7, 8-аас өвгөн лам нар ирчихнэ.

Эрхэмийн аймгийн унзад нь Гэлэгдорж, гэсгүйг нь мэдэхгүй.

Гол шүтээн нь Доржпагма байсан.

Цогчинд нь гол номоо хурна. Аймгийн дуганд сахиусууд хурна. Шинийн 8, 10, 15, 29-нд Цогчинтой. Манай багшийг Агваан гэдэг байсан. Би Итгэл, Лхам, Ганданлхавжаа үзэж төгсгөж байсан. Өмнө нь хийдийг 1 жил байна уу 2 жил ч байна уу хаагаад дахиж нээсэн юм. Тэр үед Хүрээнд байсан лам нар чинь шашин хачин боллоо гээд авгай хүүхэд авах нь аваад явсан юм. Мөн ч олон хүн баригдсан даа. Манай аймагт Чойжоосүрэн гэдэг лам байсан. 2 хашаатай айл байсан. 1 хашаанд нь мод түлээ нь нөгөө нь гэр орон нь байдаг байсан. Тэр ламыг барьсан. Тэгээд сүүлд нь баахан цагдаа нар бурханыг нь ачаад явсан гэдэг. Одоо номын сан байгаа бол гал зуух байсан. Баруун дугананд хурлаа хурна. Хойд талынханд нь гэсгүй хамба сууна.

Бид нар хаагдаж байхыг нь хараагүй. Шашин бол дээр үед их дэлгэрэнгүй байсан. Одоо ч гэсэн тэр хэвэндээ л байна.